



InvesCore FI

Listed on
LONDON
STOCK
EXCHANGE

“ИНВЕСКОР ББСБ” ХК

**ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ**

2026 оны 4 сарын 29-ний өдөр

АГУУЛГА

- 1 Хурлын зар
- 2 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах
Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
- 3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
- 4 Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт
бичгийн жагсаалт, танилцах газар, хугацаа
- 5 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
санал авах хуудас
- 6 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төслүүд
 - Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг батлах;
 - Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн батлах тухай;



Хурлын зар

“ИНВЕСКОР ББСБ” ХК – ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 19-ны өдрийн 26/12 тоот тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах боллоо.

Компанийн оноосон нэр:

Инвескор ББСБ ХК

Хурлын төрөл:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Хурал хуралдах өдөр,
цаг:

2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр, 14:00 цагт

Хурал хуралдах газар:

Компанийн веб хуудас, Инвескор Аппликейшнаар дамжуулан
цахим хэлбэрээр болон

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж,
Ай Си Тауэр барилга, 5 давхрын хурлын өрөөнд танхимаар
зохион байгуулагдана.

Бүртгэлийн өдөр:

2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг батлах;
3. Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн батлах, Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай;

Хурлаар хэлэлцэх асуудлын баримт бичигтэй танилцах газар, хугацаа

Хувьцаа эзэмшигчид нь 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд www.invescore.mn цахим хуудсаар дамжуулан эсвэл өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон Компанийн төв байранд Даваа-Баасан гаригт 09:00-18:00 цагийн хооронд ирж хурлын баримт бичигтэй танилцах боломжтой.

Урьдчилан санал өгөх

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид нь саналын хуудсыг урьдчилан бөглөж өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан эсвэл InvesCore аппликейшнээр дамжуулан саналаа өгөх боломжтой бөгөөд санал авах сүүлийн хугацаа 2026 оны 4-р сарын 28-ны өдрийн 16:00 цагаас өмнө байна.

Хувьцаа эзэмшигчийн хуралтай холбоотой асуудлаар мэдээлэл авах бол Хурал зохион байгуулах комиссын shareholders@invescore.mn цахим хаягаар болон 7709-0077 дугаараар холбогдоно уу.

Инвескор ББСБ ХК хурал зохион байгуулах комисс



Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 19-ний өдөр

№ 26/12

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 65 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам"-г тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 14:00 цагт танхим болон цахимаар хосолмол хэлбэрээр зохион байгуулахаар зарласугай;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах газрыг Компанийн төв оффис болох Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж, Ай Си Тауэр барилгын 5 давхрын хурлын танхим байхаар тогтоосугай;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай; Үүнд:
 - 3.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг батлах;
 - 3.3. Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн батлах тухай;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон "Монголын хөрөнгийн бирж" ХК-д хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс /Б.Буд/-д үүрэг болгосугай;
6. Компанийн "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар"-ыг тогтоолын Нэгдүгээр Хавсралтаар баталж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз болон Компанийн цахим хуудсаар дамжуулан 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд мэдээлж, зарын давталтыг 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр болон 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрүүдэд анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй;
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталж, баримт бичгийг 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчид үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс /Б.Буд/-д үүрэг болгосугай;
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Саналын хуудасны агуулгыг Компанийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, "Саналын хуудас"-ны загварыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, батлуулахыг Хурал зохион байгуулах комисс /Б.Буд/-д үүрэг болгосугай;
9. Компанийн хувьцаа эзэмшигчдэд 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс хойш Компанийн төв оффист ирж Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Оролмаа/, болон Хурал зохион байгуулах комисс /Б.Буд/-д даалгасугай;



Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

10. Үнэт цаасны брокер, дилерийн компаниудаар дамжуулан биетээр, Инвекор Аппликейшн, вэб хуудсаар дамжуулан цахимаар хувьцаа эзэмшигчдээс "Саналын хуудас"-аар урьдчилан санал авах хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 16:00 цагийн хооронд тогтоосугай;
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар "Инвекор ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/Д. Баясгалан/-г томилсугай;
12. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:
- 12.1. Хурал зохион байгуулах комиссын дарга:
Б.Буд Эрсдэлийн удирдлага, комплаенсын газрын захирал/
ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
- 12.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
- | | |
|----------------|-----------------------------------|
| М.Энхжин | Хуульч /ТУЗ-ийн ажлын алба |
| П.Гунанбаатар | Хуульч |
| Д.Хонгорзул | Маркетингийн менежер |
| Т.Номуундарь | Харилцагчийн үйлчилгээний менежер |
| Б.Алтанзагас | Хүний нөөцийн газрын захирал |
| Н.Отгон-Эрдэнэ | Нөөцийн удирдлагын газрын захирал |
| С.Буяндэлгэр | Бизнесийн хөгжүүлэлтийн менежер |
13. Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:
- 13.1. Тооллогын комиссын дарга:
Б.Энхжин "Инвекор ББСБ" ХК Аудитор
- 13.2. Тооллогын комиссын гишүүд:
Э.Цолмон "Инвекор ББСБ" ХК Аудитор
М.Энхзул "Инвекор ББСБ" ХК Санхүүгийн ахлах менежер
14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д. Оролмаа/, Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б. Буд/-д тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА





Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын
19-ний өдрийн хурлын 26/12 тоот Тогтоолын Нэгдүгээр хэсэгд

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР



Компанийн оноосон нэр:	Инвескор ББСБ ХК
Хурлын төрөл:	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
Хурал хуралдах өдөр, цаг:	2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр, 14:00 цагт
Хурал хуралдах газар:	Инвескор Аппликейшн болон веб хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж, Ай Си Тауэр барилга, 5 давхрын хурлын өрөөнд танхимаар
Бүртгэлийн өдөр:	2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр
Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал:	1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах; 2. ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг батлах; 3. Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн батлах тухай;
Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:	Хувьцаа эзэмшигчид нь 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хооронд компани өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Компанийн төв байранд ирж хурлын баримт бичигтэй танилцах боломжтой. Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гаригт 09:00-18:00 цагийн хооронд ажиллана.
Хурал хуралдуулах шийдвэрийн огноо, дугаар:	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 26/12 тоот тогтоол.
Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн:	Хурлын комиссын дарга: Инвескор ББСБ ХК-ийн Эрсдэлийн удирдлага, комплааснын газрын захирал/ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, bud@invescore.mn Хурлын комиссын гишүүд: 1. Хуульч/ТУЗ-ийн ажлын алба, М.Энхжин, enkhjin@invescore.mn 2. Хуульч, П.Гунанбаатар, gunanbaatar@invescore.mn 3. Маркетингийн менежер, Д.Хонгорзул, khongorzul.d@invescore.mn 4. Харилцагчийн үйлчилгээний менежер, Т.Номуундарь, nomuundari@invescore.mn 5. Хүний нөөцийн газрын захирал, Б.Алтанзагас, altanzagas@invescore.mn 6. Нөөцийн удирдлагын газрын захирал, Н.Отгон-Эрдэнэ, otgon-erdene@invescore.mn 7. Бизнесийн хөгжүүлэлтийн менежер, С.Буяндэлгэр, buyandelger.s@invescore.mn

__оОо__



Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

“ИНВЕСКОР ББСБ” ХК

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 19-ний өдрийн хурлын 26/12 тоот Тогтоолын Хөдөлгөөнийг хэвлэснийг

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ
ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн жагсаалт
1	“Инвескор ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 26/12 тоот тогтоол;
2	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар;
3	Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4	Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны загвар;
5	“Инвескор ББСБ” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан;
6	“Инвескор ББСБ” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
7	“Инвескор ББСБ” ХК-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол;
8	“Инвескор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийн санал;
9	“Инвескор ББСБ” ХК-ийн хувьцаа хуваах санал;
10	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийн төсөл;



Хурлын хөтөлбөр, дэг

Хугацаа	Хөтөлбөр	Танилцуулах
13:00-14:00	Хурлын ирц бүртгэл	Хурал зохион байгуулах комисс
14:00-14:05	Хурлын ирц мэдээлэх	Тооллогын комисс
14:05-14:10	Хурлын хөтөлбөр, дэгийг танилцуулах	Хурлын дарга

Хурлаар танилцуулах асуудал

14:10 - 14:25	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах	Гүйцэтгэх захирал
14:25 - 14:35	ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах	ТУЗ-ийн хараат бус гишүүн

Хурлаар танилцуулах асуудал

14:35 – 14:40	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг танилцуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
14:40 - 14:45	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийн санал танилцуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
14:45 - 15:00	Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн батлах асуудлыг танилцуулах	Санхүү хариуцсан захирал
15:00 - 15:15	Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбоотой асуулт, хариулт	Гүйцэтгэх захирал
15:15 - 15:25	Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах	Тооллогын комисс
15:25 - 15:40	Завсарлага /санал хураалтын дүнг нэгтгэх/	Тооллогын комисс
15:40 - 15:43	Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулах	Тооллогын комисс
15:43 - 15:48	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж батлуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
15:48 - 15:50	Хурлыг хаах	Хурлын дарга

Хурлыг дэг, санамж:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал батлагдсан цагийн хуваарь, дэгийн дагуу явагдана.
- Хурлын дундуур хурлыг орхин явах тохиолдолд тооллогын комисст мэдэгдэж саналаа урьдчилан өгч бүртгүүлнэ.
- Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд тусгагдаагүй нэмэлт асуудлыг хэлэлцэхгүй.
- Хурлын явцыг зориудаар үймүүлэх, саатуулах, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, гүтгэхийг хориглоно.



Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт

Хувьцаа эзэмшигчид нь дараах бичиг баримттай танилцах боломжтой.

1. “Инвескор ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 26/12 тоот тогтоол;
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны загвар;
5. “Инвескор ББСБ” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан;
6. “Инвескор ББСБ” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
7. “Инвескор ББСБ” ХК-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг дүгнэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол;
8. “Инвескор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийн санал;
9. “Инвескор ББСБ” ХК-ийн хувьцаа хуваах санал;
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийн төсөл;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2026 оны 4 сарын 08-ны өдрөөр тасалбар болгох бөгөөд хувьцаа эзэмшигчид нь 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хооронд дараах хэлбэрээр хурлын материалтай танилцах боломжтой.

- www.invescore.mn цахим хуудсаар
- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан эсвэл
- Инвескор ББСБ-ын төв байранд Даваа-Баасан гаригт 09:00-18:00 цагийн хооронд ирж хурлын баримт бичигтэй танилцах боломжтой.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудас



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын
25-ны өдрийн хурлын 26/15 тоот Тогтоолын Нэгдүгээр хэсгээр хавсралт 119286783
УЛААНБААТАР ХОТ

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл:

Эцэг эхийн нэр: _____ Өөрийн нэр: _____

Регистрийн дугаар/ ИБД: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Бүртгэсэн Брокер, дилерийн компанийн нэр _____

Энэхүү Саналын хуудсаар 2026 оны 04-р сарын 29-ний өдрийн 14:00 цагт Компанийн веб сайт, Инвескор Аппликейшнээр дамжуулан цахимаар болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж, Ай Си Тауэр барилга, 5 давхрын хурлын өрөөнд танхимаар хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Санал хураах арга: **Энгийн арга**

Хувьцаа эзэмшигч та саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт ☒ тэмдгийг бичнэ үү.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;	Шийдвэр А/01			
2.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг батлах;	Шийдвэр А/02			
3.	Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн батлах, Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай;	Шийдвэр А/03			

Санамж:

- Хувьцаа эзэмшигч нь энэхүү саналын хуудсаар дамжуулан **урьдчилсан санал өгөх** тохиолдолд доорх 2 хэлбэрээр 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16:00 цагаас өмнө өгөх боломжтой. Үүнд:
 - Өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компанид очин, хурлын материалтай танилцаж саналаа цаасаар өгөх,
 - Инвескор Аппликейшн болон вэб хуудсаар дамжуулан цахимаар өгөх боломжтой.**Та урьдчилан санал өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй болно.**
- Хувь хүн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан санал өгөх** тохиолдолд нотариатаар итгэмжлэл олгосон байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна. Итгэмжлэлийг саналын хуудсанд хавсаргана.
- Хуулийн этгээдийн хувьд** хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд эсхүл түүнээс эрх олгосон этгээд санал өгнө. Энэ тохиолдолд Хуулийн этгээдийн Улсын бүтгэлийн гэрчилгээ болон эрх олгосон тушаал, албан тоотыг хавсаргана.
- Засварласан, балласан, залруулгатай, ☒ тэмдгээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн, нэгээс олон санал өгсөн саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____ /гарын үсэг, хуулийн этгээдийн хувьд тэмдэг/

Брокерийн гарын үсэг _____ /гарын үсэг, хуулийн этгээдийн тэмдэг/

2026 оны 04-р сарын ____ -ны өдөр



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудас

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс бөглөнө.
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын комиссын дарга _____
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын комиссын гишүүд _____
Саналын хуудас хүчингүйд тооцсон бол шалтгаан _____



Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төслүүд



**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/01

Улаанбаатар хот

*Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид **“Компани”** гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.9 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-иар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Энэхүү шийдвэрийг Монгол Улсын Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хугацаанд зохих журмын дагуу мэдээлж, эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

Д. БАЯСГАЛАН



**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.12 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг шийдвэрийн Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү шийдвэрийг Монгол Улсын Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хугацаанд зохих журмын дагуу мэдээлж, эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

Д. БАЯСГАЛАН



*“Инвекор ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний
өдрийн А/02 тоот шийдвэрийн Хавсралт 01*

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

Зардлын төрөл	Давтамж	Дүн /төг/	Нийт дүн /төг/
ТУЗ-ийн гишүүдийн цалин	12 удаа	29,976,458	359,717,500
ТУЗ-ийн ажлын албаны цалин	12 удаа	2,500,000	30,000,000
ТУЗ албан томилолт	1 удаа	45,000,000	45,000,000
ТУЗ-ийн хурлын зардал	4 удаа	250,000	1,000,000
ТУЗ-ийн гишүүдийн сургалт	1 удаа	5,000,000	5,000,000
Бусад зардал	-	5,600,000	5,600,000
Нийт дүн			434,717,500

**2027 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг
дуустал 12 сарын нэгтгэсэн дүнгээр*

__oOo__



**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/03

Улаанбаатар хот

*Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн батлах
Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт батлах*

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.6 дахь заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.6 болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 82,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаа, 75,744,281 ширхэг гаргасан энгийн хувьцаа бүрийг 10-т хувааж, нэг бүр нь 22.7 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 820,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаа, 757,442,810 ширхэг гаргасан энгийн хувьцаа болгон хуваасугай.
2. Компанийн хувьцааг хуваах зорилго, үндэслэл, хувьцаа хуваах ажлыг гүйцэтгэх журмыг тусгасан “Хувьцаа хуваах төсөл”-ийг шийдвэрийн Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Компанийн хувьцааг хуваасантай холбоотой өөрчлөлтийг тусгасан Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийг шийдвэрийн Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
4. Энэхүү шийдвэрт заасны дагуу үнэт цаасны бүртгэлд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх, зөвшөөрөл олгосон тохиолдолд Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэх, зохих бүртгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Оролмаа/-д даалгасугай.
5. Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн баталсантай холбогдуулан Компанийн 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын А/05 дугаар “Компанийн хувьцаа хуваах төслийг батлах тухай” шийдвэр болон 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын А/03 дугаар “Компанийн хувьцаа хуваах шийдвэрт өөрчлөлт оруулах тухай” шийдвэрүүдийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.




6. Энэхүү шийдвэрийг Монгол Улсын Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хугацаанд зохих журмын дагуу мэдээлж, эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

Д. БАЯСГАЛАН

InvesCore FI



+976 7709-0077

info@invescore.mn

www.invescore.mn